



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/50

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 164 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.3.20 дугаартай Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Тарагт сум/-д зарцуулах төсөл, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100111

Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 10-ны өдрийн 750 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ /ӨВӨРХАНГАЙ, АРВАЙХЭЭР, ТАРАГТ СУМ/
ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Цагдаагийн газрын тоног төхөөрөмжийн шинэчлэл	30,000.0
2	Мэргэжлийн хяналтын газрын тоног төхөөрөмжийн шинэчлэл	20,000.0
3	Тарагт сумын ИТХ, ЗДТГ, багийн ИНХ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	20,000.0
4	Арвайхээр сумын ИТХ, ЗДТГ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	30,000.0
5	Аймгийн ИТХ, ЗДТГ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	40,000.0
6	Аймгийн Засаг даргын дэргэдэх ГХБХБГ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	20,000.0
7	Аймгийн Засаг даргын дэргэдэх ГБХЗХГ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	30,000.0
8	Аймгийн Засаг даргын дэргэдэх БСУГ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	10,000.0
	НИЙТ ДҮН	200,000.0